

ЭМГ-ын 7 хоногийн мэдээ

Зарим статистик үзүүлэлтүүд

- Нийт төрөлт 62
- Амьд төрөлт 63
- Амьгүй төрөлт
- Дутуу төрөлт
- Нялхсын эндэгдэл
- 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1
- Эхийн ноцтой хүндрэл
- Төрөлхийн гажиг 2
- Гэрийн төрөлт

ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ :

- **Тусламж үзүүлэх талаар :**
- 4 багийн иргэн Даулетханы гэр бүлийн амьдралтай танилцаж ,тусламжийн гараа сунган хүнсний тусламжийг үзүүлэн, байгууллагын ажилчдад танилцуулан , хөдөлгөөн өрнүүлж ,эхний ээлжинд 1 тн нүүрсний тусламжийг ажилчдын дэмжлэгтэйгээр хүргэсэн . Дараагийн ээлжинд Кальцийн бэлдмэлээр хангахаар болж байна.
- **- Томуу, томуу төст өвчний эрсдэлээс сэргийлэх чиглэлээр:**

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (216)-ийн дотор 13 буюу 6%-ийг эзэлж,өмнөх долоо хоногтой харьцуулахад 1.6%-иар нэмэгдсэн үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна. Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 272 дуудлагын 12,5%-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж, үүнээс ТТӨ-ий шалтгаантай дуудлага 34(12,5%)-ийг эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 3,6%-иар буурсан үзүүлэлтэй байна. Аймгийн хэмжээнд 2017 оны 43 дугаар 7 хоногт аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын тандалтын нэгжүүд томуу, томуу төст өвчний тохиолдол 18 удаа ирүүлэхээс 17(94,4%) удаа ирүүлсэн

байна. Аймгийн хэмжээнд 42 дах долоо хоногт тандалтын нэгжүүдээс мэдээ ирүүлэлтийн байдал 100% -тай байсан бол 2017 оны 43 дах долоо хоногт мэдээ ирүүлэлт 94,4% -тай байна.

Томуу, томуу төст өвчний эрсдэлээс сэргийлэх мэдээлэл сурталчилгааны төлөвлөгөөний удирдамж боловсруулан ЭМГ-ын даргаар батлуулан хэрэгжүүлж байгаа ба, өрх сумдын эрүүл мэндийн төвүүдийг мэргэжлийн арга зүйн зөвлөгөөгөөр ханган Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлье, томуугийн цэгэн массаж, Салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтанд нийтдээ сургуулийн 3510 багш, сурагчид, цэцэрлэгийн нийт 1714 хүүхэд, багш нар болон 1121 ард иргэд, эрсдэлтэй бүлгийн хүмүүст мэдээлэл сургалт сурталчилгаа хийсэн. Аймгийн төвийн бүх цэцэрлэгүүдэд хүүхдүүдийн ирцийн бүртгэлийн тандалт судалгаа хийж, Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлье сэдэвт сургалтыг нийт 160 ажилчдад явуулж, Нийгмийн эрүүл мэндийн төвөөс гаргасан инфографик, зөвлөмжүүдийг өгч ажилласан. Жансая, Рауан, Шипагер, Мейрим ӨЭМТ-үүдийн нийт 45 эмч, ажилчдад эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар тушаал, А/346 дугаар тушаалуудыг танилцуулж сургалт зохион байгуулсан. ЭМГ-ийн нийт 46 ажилчдад Томуугийн харуулдан тандалтын талаар дотоод сургалт явуулсан. Хэвлэл мэдээллийн Наз, Дербес, ТВ-4 хэрэгслүүдээр 7 хоногт 1 удаа Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 2 удаа ярилцлага, зөвлөмж өгч, зөвлөмж шторкуудыг давтагдсан тоогоор 14 удаа тогтмол явуулж байна. Энэ долоо хоногоос эхэлж аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн хүүхдүүдээс сорьц авахаар төлөвлөж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх, дотор гэх мэт тасгуудад хог хаягдал, халдвар хамгааллын асуудлаар ЭМС-ын 186, 187, 169 тоот тушаалын хэрэгжилтэнд дэмжлэгт хяналт үнэлгээ хийсэн. Ногооннуур Сум сумдын эмнэлэгт энэ 7 хоног салхинцэцэг өвчнөөр 1 тохиолдол нэмэгдэж хариу арга хэмжээ авч, тандалт судалгаа хийж мэргэжлийн арга зүйгээр ханган ажилласан.

Халдварт өвчний чиглэлээр :

- 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Томуугийн эсрэг вакцины сайн дурын дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд Сайн дурын дархлаажуулалтыг ЭМГ-т дархлаажуулалтын кабинетэд хийж байгаа ба нийтдээ 36 хүүхдийг хамруулсан.
- Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооноос “Эрүүл мэндийн ажилтныг эрсдлээс сэргийлэх жил” болгон зарласантай холбоотой эмч эмнэлгийн ажилчдын дундах сүрьеэгийн халдварлалтын байдлыг тодорхойлох зорилгоор “Эмч, эмнэлгийн ажилчдад туберкулины сорил тавих тухай” Эрүүл мэндийн газрын даргын А/58 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж ажиллаж байна.
- Ногооннуур сум дундын эмнэлэгт сүрьеэгийн үргэлжлэх шатны эмчилгээ хийлгэх нэг өвчтөнг гурвалсан гэрээний дагуу шилжүүлсэн .

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр:

- Бүх сургууль цэцэрлэгүүдийн 40 эмч нарт зориулсан “Амны хөндийн эрүүл мэнд “ сэдвийн сургалтыг НТБЭМАШТҮБ-2 төслөөс зохион байгуулан орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр Дербес ТВ, радиогоор сурталчилсан
- 9 цагийн Радиогоор умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх , зөв зохистой хооллолт ,томуугаас сэргийлье ,охидын эрүүл мэндийн талаар МҮОНРТ-ээр ярилцлага өгсөн.

Сургалт сурталчилгааны чиглэлээр :

Сурагчдын амралтын үеэр 2-бүрэн дунд сургуулийн 55 багш нарт ХБӨ-ний эрсдлээс сэргийлье , Амны хөндийн эрүүл мэнд ,Томуугаас сэргийлье,Угаарын хийн хордлогоос сэргийлье сэдвүүдээр 4 цагийн сургалт явуулсан.

Бүх сургууль цэцэрлэгүүдийн 40 эмч нарт зориулсан “Амны хөндийн эрүүл мэнд “ сэдвийн сургалтыг НТБЭМАШТҮБ-2 төслөөс зохион байгуулсан.

.Олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр :

АЗДТГазар, Номын сан, ЭМД Хэлтэс, Татвар, БСУГ-ын ажилтан албан хаагчдаас БЖИ-ийн судалгаа авч байгаа ба нийдээт 92 хүн хамрагдсан . Эрүүл мэндийн

сайдын 2011 оны 158,305 дугаар тушаалуудын дагуу Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах талаар сар бүр мэдээ авах талаар албан тоот боловсруулж НЭ, өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн.

Хяналт үнэлгээний чиглэлээр :

АНЭ-ийн төрөх тасагт НЭМ болон ёс зүйн чиглэлээр мөн үр хөндөлтөнд эмийн зохистой хэрэглээг сайжруулах болон халдвар хамгаалаллын талаар хяналт үнэлгээний баг томилогдон ажиллаж байна. ДЗОУБ БӨОНХХ-аас нийлүүлэгдсэн ус цэвэршүүлэгчийн суурилалтанд ба ашиглалтанд хяналт үнэлгээ хийсэн .

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158,305 дугаар тушаалуудын дагуу Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах талаар сар бүр мэдээ авах талаар албан тоот боловсруулж НЭ, өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн.

Алтай, Буянт сумдад 4 хоног ажиллаж тус сумдын ЗДТГ, эрүүл мэндийн төв, сургуулийн эрүүл мэндийн тусламжийн байдалд хяналт үнэлгээ хийсэн. Үүнд:

1. Байгууллагын хэтийн болон ойрын үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн байдал
2. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал
3. Бүх ажилчдын ажлын байрны тодорхойлолтын хэрэгжилт
4. Бүх ажилчдын хувийн хэргийн бүрдэлт
5. Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн эрүүл мэндийн тусламжийн зорилтын хэрэгжилтийн байдал
6. Сумын ЗДТГ, эрүүл мэндийн төвийн ажлын уялдаа холбоо зэрэг үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийсэн.